

## ТАНИЛЦУУЛГА

“Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 22 дугаар зүйлд “Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй.” хэмээн иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх нь улс төрийн болон нийгэм соёлын бусад эрхээ эдлэх, хамтдаа улс орны хөгжлийн үйл явцад оролцох боломжийг хангахад чухал нөлөөтэй болохыг тодотгон гишүүн улс орнуудын Засгийн газрыг үүрэгжүүлсэн байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3-т “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.” хэмээн тодорхойлж, улмаар тус чиглэлд аюулгүй байдлыг хангахын тулд “... аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллагаар... гүйцэтгүүлэх бодлого баримтална.”, “Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ” хэмээн тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилго 5-д “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, **төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин**, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэсэн зорилтыг дэвшүүлж, энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үе шатыг “Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо хангагдаж, хамтын ажиллагаа бэхжих нөхцөл бүрдэнэ.” гэж, “Иргэний нийгмийн байгууллагууд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж тус тус тусгасан.

Иргэний нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт болох төрийн бус байгууллага, шашны байгууллага, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл зэрэг бүрэлдэхүүн хэсгийн эрх зүйн орчин, тухайлбал, Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 он, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль 1993 онд, Улс төрийн намын тухай хууль 2005 он, Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль 1991 онд тус тус батлагдаж тус тусдаа эрх зүйн орчин нь бүрдсэн байдаг.

Хэдийгээр сүм хийд, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, худалдаа аж үйлдвэрийн танхим, улаан загалмайн байгууллага зэрэг эрх зүйн тусгай зохицуулалттай боловч эдгээрийг бүгдийг хамруулсан нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна.

Түүнчлэн Иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагын чадамжийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох зорилго бүхий иргэний нийгмийн талаар төрөөс баримтлах бие даасан бодлого зайлшгүй шаардлагатай байна.

Ийнхүү ардчиллын үнэт зүйлийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, төрийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналтад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих, чадварлаг, хараат бус иргэний нийгмийг бүрдүүлэх, төр, иргэний нийгмийн бүтээлч хамтын ажиллагааг төгөлдөршүүлэхэд чиглэсэн төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогыг тодорхойлж, ийнхүү төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа нь улсын хөгжлийг хангах суурь стратеги болно гэж үзэж байна.

Дээр дурдсан олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс бие даасан “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад байна. Уг тогтоолын төсөл нь 2 зүйлтэй бөгөөд нэг дүгээр зүйлд “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ыг хавсралтаар батлах, хоёрдугаар зүйлд уг баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих талаар тусгасан болно. Улсын Их Хурлын тогтоолыг ердийн журмаар дагаж мөрдөх болно.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11-д “Бусад хууль тогтоомжид заасан “төрөөс баримтлах бодлого” гэснийг энэ хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд, “үндэсний хөтөлбөр” гэснийг энэ хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно.” гэж, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.” гэж заасны дагуу боловсруулагдсан болно.

Тогтоолын төсөл батлагдсанаар “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ыг баримт бичигтэй болно.

Ингэснээр Монгол Улсын нэгдсэн олон улсын пактад нийцүүлэх, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг тусгасан зорилтыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

---oOo---